



**МОНГОЛ УЛС**  
**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ**  
**ТОГТООЛ**

2012 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 229

Улаанбаатар хот

“Улаанбаатар хотын даатгал” ХХК-д дүрмийн сан /хувь нийлүүлсэн, хөрөнгө/-ийн бүтэц, хэмжээндээ өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3 Даатгалын тухай хуулийн 21.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай” 333 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн дүрмийн сангийн хэмжээг тус компанийн ногдол ашгаас хувь нийлүүлэгч М.Энхболдод 55,000,000.0 /тавин таван сая/ төгрөгөөр нэмэгдүүлж, хувь нийлүүлэгч Ц.Чинбатын 100 хувь өөрийн хөрөнгө оруулсан “Танан импекс” ХХК-ийн ногдол ашгаас 445,000,000.0 /дөрвөн зуун дөчин таван сая/ төгрөгөөр нэмэгдүүлж байгаагаас хувь нийлүүлэгч М.Энхболдод нэг бүр нь 100,000.0 /Нэг зуун мянга/ төгрөгийн үнэтэй 700 /долоон зуу/ ширхэг нийт 70,000,000.0 /далан сая/ төгрөгийн хувьцааг бэлэглэлээр шилжүүлж, нийт 500,000,000.0 /таван зуун сая/ төгрөгөөр нэмэгдүүлж дараах байдлаар тогтоохыг зөвшөөрсүгэй:

	Хувь нийлүүлэгчдийн нэрс	Дүрмийн сангийн хэмжээ /мянган төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь /%/
		Эхний үлдэгдэл	Нэмэлт хөрөнгө оруулалт	Эцсийн үлдэгдэл	
1	Ц.Чинбат	710,000,000.0	375,000,000.0	1,085,000,000.0	72.33
2	М.Энхболд	250,000,000.0	125,000,000.0	375,000,000.0	25.00
3	“Улаанбаатар сан” ХХК	40,000,000.0	-	40,000,000.0	2.67
	Нийт	1,000,000,000.0	500,000,000.0	1,500,000,000.0	100.0

2. Дүрмийн сангийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн, холбогдох баримтыг 2012 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Улаанбаатар хотын даатгал” ХХК /М.Энхболд/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллах, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

001627